



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/617

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2.1, аймгийн ИТХ-ын Хуралдааны 2023 оны XVII дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 08 дугаар сарын 11-ны 08 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 29-ны 01/149 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 23-4818 дугаартай шинжилгээний хариугаар Булган сумын Рашаант 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт Африкийн гахайн мялзан өвчин оношлогдсоны улмаас тус өвчнөөр өвчилсөн 10 айл өрхийн 616 тооны гахайг булж, устгахад шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Байгал хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

2. Дээрх ажлыг хууль тогтоомж, стандартын дагуу зохион байгуулж, хариу арга хэмжээ авч ажиллахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр), мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

